

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон нийт тэтгэвэр авагчид баталгаат тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүртэл хугацаанд тооцон олгох бөгөөд баталгаат тэтгэврийн хэмжээ нь баталгаат тэтгэврийн суурь дүн (Бс)-тэй тэнцүү байна.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан тэтгэвэр авагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн өдрөөс эхлэн баталгаат тэтгэвэр (Бт), баталгаат тэтгэврийн суурь дүн (Бс)-гийн зөрүүг олгоно.

3 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш тэтгэвэр тогтоолгосон бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр (Бт)-ийг олгоно.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ